



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 13 өдөр

Дугаар: А/26

Улаанбаатар хот

Сургалтад хамруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 3.27.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.2.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Агаарын навигаци, нисэх буудал, аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний аюулгүй ажиллагаа болон гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдийг тогтоох, үнэлэх аргачлалыг тооцоолох зорилгоор Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар байгуулагдсан "Иргэний нисэхийн үндэсний төвийн агаарын навигаци, нисэх буудал, аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний аюулгүй ажиллагаа болон чанарын нэгдсэн үзүүлэлтүүдийг тогтоон батлуулах" ажлын хэсэг болон харьяа салбар, нэгжийн хавсралтад нэр дурдсан ажилтнуудыг "Могул консалтинг энд сервис" ХХК-иас 2023 оны 3 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулах "KPI essentials" сургалтад хамруулсугай.

2. Сургалтын төлбөрт 5,500,000 (таван сая таван зуун мянга) төгрөгийг зохих журмын дагуу зарцуулахыг Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар (Д.Пүрэв-Очир)-т зөвшөөрсүгэй.

3. Сургалтыг чанартай зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Аюулгүй ажиллагаа, чанарын удирдлагын алба (Х.Энхбаатар)-нд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар (Э.Нарантунгалаг)-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ

Н.БАТСАЙХАН



Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын
2023 оны 03 дугаар сарын 13.-ны өдрийн
A/26.. дугаар тушаалын хавсралт

"KPI ESSENTIALS" СУРГАЛТАД ХАМРУУЛАХ АЖИЛТНЫ НЭРС

| № | Овог нэр | Албан тушаал |
|-----|---------------|--|
| 1. | Х.Энхбаатар | Аюулгүй ажиллагаа, чанарын удирдлагын албаны дарга |
| 2. | С.Нацагдорж | Нисэх буудлуудын үйлчилгээний газрын дарга |
| 3. | Э.Төрбаяр | Агаарын навигацийн үйлчилгээний газрын дарга |
| 4. | Г.Цэвээнгэрэл | Мэдээллийн аюулгүй байдал, технологийн албаны дарга |
| 5. | Д.Пүрэв-Очир | Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газрын дарга |
| 6. | Б.Мандухай | Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны Аюулгүй байдлын удирдлагын хэсгийн дарга |
| 7. | М.Даваажав | Аюулгүй ажиллагаа, чанарын удирдлагын албаны менежер |
| 8. | З.Туяа | Захиргаа, хүний нөөцийн газрын Хууль, эрх зүй хариуцсан менежер |
| 9. | Н.Идэр | Агаарын навигацийн үйлчилгээний газрын менежер |
| 10. | Б.Нэргүй | Хамтын ажиллагааны газрын менежер |
| 11. | Д.Ариунтуяа | Захиргаа, хүний нөөцийн газрын ахлах мэргэжилтэн |
| 12. | Э.Мөнхцэцэг | Нисэх буудлуудын үйлчилгээний газрын ахлах мэргэжилтэн |
| 13. | И.Амарсанаа | Нисэх буудлуудын үйлчилгээний газрын мэргэжилтэн |
| 14. | Д.Цэцэгмаа | Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газрын эдийн засагч |
| 15. | Э.Энхболд | Аюулгүй ажиллагаа, чанарын удирдлагын албаны мэргэжилтэн |
| 16. | М.Нямсүрэн | Аюулгүй ажиллагаа, чанарын удирдлагын албаны мэргэжилтэн |
| 17. | А.Нямдагва | Аюулгүй ажиллагаа, чанарын удирдлагын албаны мэргэжилтэн |
| 18. | Д.Оюунсуvd | Аюулгүй ажиллагаа, чанарын удирдлагын албаны мэргэжилтэн |
| 19. | Э.Ганпүрэв | Аюулгүй ажиллагаа, чанарын удирдлагын албаны мэргэжилтэн |
| 20. | Н.Анхбилгүүн | Аюулгүй ажиллагаа, чанарын удирдлагын албаны мэргэжилтэн |

- - - ооо - - -